

Дугаар 34

**2003 онд нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагуудын  
жагсаалт батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийн 1.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийгмийн салбарын 2003 онд хувьчлах байгууллагуудын жагсаалт"-ыг 1 дүгээр, "Нийгмийн салбарын 2003 онд өөрчлөлт, шинэчлэлт хийх байгууллагуудын жагсаалт"-ыг 2 дугаар, "2003 онд худалдах нийгмийн салбарын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар батлагдсан нийгмийн салбарын байгууллагын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалыг холбогдох хууль тогтоомж болон "Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоолын 4 дүгээр хавсралтад дурдсан орон нутгийн өмчит нийгмийн салбарын байгууллагуудыг Төрийн өмчийн хороо, Боловсрол,соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яамтай зөвшилцөн 2003 онд өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийхийг холбогдох аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөж, Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Боловсрол, соёл, шинжлэх  
ухааны сайд

А.ЦАНЖИД

Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд

Ш.БАТБАЯР

Эрүүл мэндийн сайд

П.НЯМДАВАА

Хянасан:

Монгол Улсын Засгийн газрын  
Хэрэг эрхлэх газрын дарга  
Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2003 оны 34 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙГМИЙН САЛБАРЫН 2003 ОНД ХУВЬЧЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

д/д	Байгууллагын нэр	Байршил	Төрийн эзэмшлийн хувь		Хувьчлалыг зарлах хугацаа	Хувьчлах арга, хэлбэр, нөхцөл
			Нийт хувь	Үүнээс: хувьч-лах хувь		

I. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР

1	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	-	П улирал	Хөрөнгө оруулах нөхцөлтэйгээр менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
2	Улаанбаатар их сургууль	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	100	100	Ш улирал	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
3	Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	100	П улирал	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
4	Үйлдвэрлэл урлалын сургууль	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	100	П улирал	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
5	Монгол кино нэгтгэл	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	100	100	IV улирал	2003 онд Баримтат кино студийг тусад нь бие даалган зохион байгуулж, Монгол кино нэгтгэлийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
6	Заамарын МСҮ төв	Төв. Заамар сум	100	100	П улирал	Зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах

7	ХАА-н техникийн корпораци	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	100	100	П улирал	Зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
8	Техник, технологийн коллеж	Улаанбаатар Баянгол дүүрэг	100	-	Ш улирал	Гадаад, дотоодын нэмэлт хөрөнгө оруулалт хийж хамтарсан өмчит сургууль хэлбэрээр зохион байгуулж хувьчлах
9	“Армоно” корпораци	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	100	100	Ш улирал	Өрийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тохиролцсоны дараа нээлттэй уралдаант шалгаруулалт (төсөл шалгаруулах)-ын аргаар хувьчлах
10	Сэргээгдэх эрчим хүчний корпораци	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	100	100	Ш улирал	Зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
11	Улсын цирк	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	51	IV улирал	Хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж хувьцааны 51 хувийг зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгээр нээлттэй уралдаант

						шалгаруулалтын аргаар хувьчлах
П. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР						
12	Хужирт рашаан сувилал	Өвөрхангай Хужирт сум	100	100	П улирал	Хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж, нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
13	Монголэмимпэкс концерн	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	49	П улирал	Хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж, хувьцааны 49 хувийг нэг багц болгон нээлттэй дуудлагын худалдааны аргаар хувьчлах
14	Эмийн үйлдвэр УҮГ	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	100	Ш улирал	Хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж, нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
15	"Монсам" ХХК	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	80	80	Ш улирал	БНСУ-ын хөрөнгө оруулалтын зээлийн асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр Компанийн тухай хуулийн дагуу бусад хувь нийлүүлэгчдэд санал болгож, татгалзсан нөхцөлд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
16	"Эрүүл энх" хэвлэлийн үйлдвэр	Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	100	100	Ш улирал	ДЭМБ-аас хөрөнгө оруулалтаар оруулсан тоног

						төхөөрөмжийн дүнг хасч үлдсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлах
17	"Цагаан нуга" хүүхдийн зуслан	Төв Батсүмбэр сум	100	100	П улирал	Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
18	Клиникийн нэгдсэн Ш эмнэлэг	Улаанбаатар Баянгол дүүрэг	100	100	IV улирал	Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
19	Шаргалжуут рашаан сувилал	Баянхонгор Баянхонгор сум	100	100	П улирал	Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах